

**ЭНГИЙН ИРГЭД БОЛОН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН
ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

(Монгол, Япон, ОХУ, Казакстан, Швед, БНЧУ)

*Ц. Товуусүрэн, П. Амаржаргал, Б. Мөнхцэцэг,
А. Пагма, Б. Хатантуул***Оршил**

Өндөр хөгжилтэй орнуудад хүн амын нийгмийн хамгааллын систем төлөвшиж, ядуурал, ажилгүйдэл зэрэг асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэж иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл бүрджээ. Улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн амжилт нь “нийгмийн зөвшилцөл дээр суурилсан сайтар бодож боловсруулсан нийгмийн хамгааллын системтэй холбоотой” гэдэгтэй эрдэмтэд, судлаачид сүүлийн жилүүдэд санал нэгдэж байна. Гэхдээ нийгмийн хамгаалалын асуудал нь онол арга зүйн талаасаа нарийвчлагдан судлагдаагүй, маргаантай асуудлын нэг хэвээр байна.

Нэрний хувьд ч янз бүрээр нэрлэгдэж байна. Тухайлбал, “нийгмийн хамгаалал”, “бүх нийтийн хангалуун байдал”, “нийгмийн үйлчилгээ”, “эдийн засгийн хамгаалал” “нийгмийн дэмжлэг” гэх мэт олон янзаар нэрлэгдэж хамрах хүрээний хувьд “бүх нийтийг хамрах”, “эмзэг хэсгийг хамгаалах”, “ажилчдыг хамгаалах” гэсэн олон хувилбаруудыг улс бүр өөр өөрөөр хэрэглэж байна.

“Дэлхийн нийгмийн хамгааллын хөтөлбөр” /Social Security Program Throughout the World буюу “SSPTW” нь 178 орны нийгмийн хамгааллын асуудлыг нэгдсэн системд оруулсан. Энэ хөтөлбөрийг АНУ-ын нийгмийн хамгааллын захиргаа/ U.S.Social Security Administration “SSA”, /Олон улсын нийгмийн хамгааллын холбоо/ International Social Security Association “ISSA”/ хамтарч боловсруулдаг бөгөөд гишүүн орнуудын тайлан мэдээг үндэслэн 2-3 жил тутам шинэчлэгдэж байдаг.

Энэ хөтөлбөрт Ази, Номхон далайн - 51, Европын 45, Америкийн 37, Африкийн 45 нийт 178 орнууд хамрагдаж нийгмийн хамгааллын асуудлууд нь нэгтгэгдсэн боловч Монгол улс одоогоор хамрагдаж чадаагүй байна. Энэ нь манай улсад зах зээлийн шилжилтийн үйл явц үргэлжилж байгаагаар тайлбарлагдаж болох боловч Орос, Киргиз, Казахстан, Вьетнам, Комбож, Польш, Унгар орнууд дэлхийн нийгмийн хамгааллын системд нэгджээ.

Энэ судалгаанд Монгол Улсын энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамж үйлчилгээний талаархи өнөөгийн байдал, мөн ОХУ, БНКаЗУ, Швед, Чех, Япон улсын холбогдох хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр тэтгэмж, нийгмийн хамгааллын талаар хэрхэн зохицуулсаныг судлав.

Монгол Улсын энгийн иргэд ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр тэтгэмж, группын тэтгэвэр, нийгмийн хамгаалал халамжийн харьцуулсан судалгаа

Монгол улсын хэмжээнд иргэдийн тэтгэвэр тэтгэмж, группын тэтгэвэр, нийгмийн хамгаалал халамжийн асуудал нь дараахи 9 хуулиар зохицуулагдаж байна.Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль 1994.05.31
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай 1994.06.13
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль 2002.04.25
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай 1994.06.07

- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай 1994.07.05
- Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай 1994.06.13
- Нийгмийн халамжийн тухай хууль 2005.12.01
- Ахмад настны нийгмийн хамгааллын тухай 2005.12.08
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай 2005.12.08

Эдгээр хуулийн хүрээнд тэтгэвэр тэтгэмж нийгмийн халамжууд нь тус тусын сангуудаас санхүүжигдаж явна.Үүнд:

- Нийгмийн даатгалын сан / орлогын эх үүсвэр нь даатгуулагчийн төлсөн НДШ, ажил олгогчийн төлсөн НДШ, сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, үнэт цаасны арилжаанаас олсон орлого, НДШ төлөх хугацаа хэтрүүлсэнд оногдуулсан алданги, улсын төсвөөс олгох хөрөнгө,
- Халамжийн сан, / орлогын эх үүсвэр нь төсвөөс олгох хөрөнгө, сангийн хөрөнгийн үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, ОУБ, гадаад орнуудаас өгсөн хандив тусламж, ААН байгууллага, иргэнээс өгсөн хандив тусламж, бусад эх үүсвэр.

НЭГ: МОНГОЛ УЛСЫН ТЭТГЭВРИЙН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ, ТЭТГЭВЭР АВАГСАД

1.1/ Нийгмийн даатгалын сангийн тэтгэврийн даатгалын сангаас олгох

Өндөр насны тэтгэвэр – 20- оос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл / ТДШ/ төлсөн 60 хүрсэн эрэгтэй , эмэгтэй хүн бүр. Хэрвээ өөрөө хүсвэл 55 нас хүрсэн эмэгтэй. 2010 оны III улирлын байдлаар 200372 иргэн өндөр насны тэтгэвэр авч байна. Хавсралт №1/

Тахир дутуугийн тэтгэвэр – ТДШ-ийг нийтдээ 20-иос доошгүй жил, эсхүл тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь төлсөн даатгуулагч ердийн өвчин, тарилгын дараахь хүндрэл, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар байнга буюу удаан хугацаагаар алдаж тахир дутуу болсон бол энэ тэтгэврийг тогтоолгон авах эрхтэй. 2010 оны III улирлын байдлаар 52669 иргэн энэ тэтгэврийг авч байна. /Хавсралт №1/

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр - ТДШ-ийг нийтдээ 20-иос доошгүй жил, эсхүл тахир дутуу болохын өмнөх 5 жилийн 3 жилд нь төлсөн тэжээгч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барвал түүний асрамжинд байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй дор дурдсан гишүүд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. 2010 оны III улирлын байдлаар 27806 иргэн энэ тэтгэвэр авсан байна. /Хавсралт №1/ НДС-ын сангаас 2010 оны III улирлын байдлаар дээрхи 3 төрлийн энгийн тэтгэвэр авагч 280847 иргэн байна. /Хавсралт №1/

1.2/ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр

Дараахь нөхцөл байдалд гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод даатгуулагч өртсөн тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно:

- ✓ ажлын байрандаа болон бусад газарт ажил үүргээ гүйцэтгэх явцад;
- ✓ ажил эхлэхийн өмнө ажилд бэлтгэх буюу дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх үед;
- ✓ ажилдаа ирэх, буцах замд

- Тахир дутуугийн тэтгэврийг даатгуулагчийн сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого /цаашид “Хөдөлмөрийн хөлс” гэх/-оос хөдөлмөрийн чадвараа 10 хүртэл хувиар алдсан бол 10 хувиар, 10-аас дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тогтооно.
- Хөдөлмөрийн чадвараа 30, түүнээс дээш хувиар алдаж тахир дутуу болсон даатгуулагчийн тахир дутуугийн тэтгэврийн хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна. 2010 оны III улиралд 6318 иргэн авсан байна. /Хавсралт №1/
- **Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх, тэтгэврийн хэмжээ** Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас даатгуулагч нас барсан бол түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Тэжээгчээ алдсаны тэтгэврийг нас барсан даатгуулагчийн авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос дор дурдсан хувь хэмжээгээр тогтооно:
 - хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 3 ба түүнээс дээш бол 100 хувь;
 - хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 2 бол 75 хувь;
 - хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 1 бол 50 хувь

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатаглын сангаас 2010 оны III улиралд тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр тэтгэмжид 7026 иргэн хамрагджээ. 2010 оны III улирлын байдлаар 708 иргэн авсан байна. /Хавсралт №1/

1.3 /Халамжийн сангаас олгох нийгмийн халамжийн тэтгэвэр

- Ахмад настны халамжийн тэтгэвэр - Тэжээн тэтгэх хүүхэд, төрөл садангийн хүнгүй, 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр - 16 насанд хүрсэн одой иргэн, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- Дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 50 насанд хүрсэн эцэг/-ийн халамжийн тэтгэвэр 16 хүртлэх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг/
- Тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхдийн халамжийн тэтгэвэр

Халамжийн сангаас олгох эдгээр 4 төрлийн тэтгэврийг Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 242 дугаар тогтоолоор сар бүр 53800 төгрөгөөр олгохоор тогтоожээ. Эдгээр тэтгэврийг 2010 онд Монгол Улсын 56677 иргэн авчээ. Хавсралт №1

ХОЁР: МОНГОЛ УЛСЫН ТЭТГЭМЖИЙН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ, ХАМРАГДАГСАД

2.1 Нийгмийн даатгалын тэтгэмжийн сангаас олгох

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
- Оршуулгын тэтгэмж
- Өвчтөн сахисны тэтгэмж

Нийгмийн даатгалын тэтгэмжийн сангаас 2010 онд Монгол Улсын нийт 90014 иргэн дээрх 4 төрлийн тэтгэмжийг авсан байна. /Хавсралт №1/

2.2 Ажилгүйдлийн даатгалын сангаас - ажилгүйдлийн тэтгэмж – 2010 онд 7942 иргэн авчээ.

2.3 Халамжийн сангийн амьжиргааг дэмжих сангаас

Нөхцөлт мөнгөн тэтгэмж

- ✓ Ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж
- ✓ Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж байгаа иргэнд олгох тэтгэмж
- ✓ Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа иргэнд олгох тэтгэмж
- ✓ Ганц бие ахмад настан иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох
- ✓ Ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох

Халамжийн сангийн амьжиргааг дэмжих сангаас Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 242 тогтоолоор дээрхи 6 төрлийн тэтгэмжид сар бүр 31200 төгрөг олгож байхаар тогтоожээ. Эдгээр тэтгэмжид 2010 онд Монгол Улсын 120846 иргэн хамрагджээ./ Хавсралт №2/

- ✓ Эхийн алдар 1,2-р зэргийн одонтой эхэд олгох тэтгэмж 127500 иргэн авсан
- ✓ Эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар тутам олгох тэтгэмж.

Энэ тэтгэмжийг 2010 онд 85243 иргэн авсан.

Нийгмийн халамжийн туслалцаа шаардлагатай өрх , иргэний амьжиргаанд үзүүлэх хөнгөлөлт тусламж

Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж

- 3 хүртэл насны ихэр хүүхдэд жилд 1 удаа 60000 төгрөг хүүхдийн тоогоор,
- Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд 1 удаа 30000 төгрөг,
- 3 ба түүнээс дээш 14 хүртлэх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхэл жилд 1 удаа 60000 төгрөг,
- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд 1 удаа 500000 төгрөг
- Гэнэтийн аюул ослын улмаас гэр оронгүй болсон өрхөд гэр авахад дэмжлэг үзүүлж 1 удаа 500000 т өгөх/
 - ✓ Орон сууцны хөлсний болон түлшний үнийн хөнгөлөлт
 - ✓ Халамжийн цэцэрлэгийн үнийн хөнгөлөлт
 - ✓ Протез, ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн хангамж
 - ✓ Сэргээн засах үйлчилгээний зардлын хөнгөлөлт
 - ✓ Эх орны рашаан сувилалын зардлын хөнгөлөлт

Энэ төрлийн хөнгөлөлт тусламж нь МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоолоор олгогддог бөгөөд 2010 онд 154013 иргэн хамрагджээ./ Хавсралт №2/

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

- ✓ Амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг дэмжих

зорилгоор зөвөлгөө өгөх, сургалт зохион байгуулах

- ✓ Зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарахад нь туслах, энэ чиглэлээр хэрэгжих төсөл хөтөлбөрүүдэд зуучлан хамруулах
 - ✓ Сэргээн засах үйлчилгээнд хамруулах
 - ✓ Түр байрлуулан асрамжлах
 - ✓ Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах

Энэ төрлийн халамж үйлчилгээний хэмжээг ХХҮГ-ыг даргын 2010 оны ... тоот тушаалын 2 дугаар хавсралтаар тогтоосон /хавсралт №3/ бөгөөд 2010 оны III улиралд 21401 иргэн хамрагджээ. /Хавсралт №2/

Төрөлжсөн халамж үйлчилгээ

- ✓ Ахмад настны асрамжийн / Тэжээн тэтгэх хүүхэд, төрөл садангүй, бие даан амьдрах чадваргүй болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настан/
- ✓ Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний / Мэргэжлийн үйлчилгээ, тусгай нөхцөл шаардсан ХБИ
- ✓ Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн асрамжийн / Хүнд нөхцөлд байгаа эсхүл байнгын асрамжинд байдаг Хөгжлийн бэрхшээлтэй 16 хүртэл насны хүүхэд/
- ✓ Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн / 4 нас хүртэл төрийн зардлаар асрамжилна/

НДС-аас оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны оршуулгын тэтгэмж

ГУРАВ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХАМРАГДАЖ БУЙ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2005 онд батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын” тухай хуульд “Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг “хөгжлийн бэрхшээлтэй” иргэн гэж тодорхойлоод эдгээр иргэд нь дараах үйлчилгээнд хамрагдах эрхтэй гэж заажээ.Үүнд:

- нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж;
- нийгмийн халамжийн тэтгэвэр;
- нөхцөлт мөнгөн тэтгэмж;
- тусламж, хөнгөлөлт;
- төрөлжсөн асрамжийн үйлчилгээ;
- олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ;
- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ;
- эрүүл мэндийн үйлчилгээ;
- боловсрол, соёл, урлагийн үйлчилгээ.

Энэ хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийгмийн халамжийн сангаас олгох тусламж хөнгөлөлтийг дурдвал:

- ✓ Бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт

- амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;
- ✓ 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг 3 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;
 - ✓ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг 5 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;
 - ✓ 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг 5 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;
 - ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн тусгай сургуульд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх;
 - ✓ Эмчилгээ, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэн дотоодын рашаан сувилалд сувилуулбал нэг талын унааны зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;
 - ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх;
 - ✓ Насанд хүрсэн бүрэн хараагүй иргэний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх;
 - ✓ Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;
 - ✓ Хараагүй хүний брайлын үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх;
 - ✓ Бүрэн хараагүй хүн эмнэлэгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчих шаардлагатай болвол ирж буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;
 - ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгох;
 - ✓ Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэн нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгох.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох хөнгөлөлт тусламж нь “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай” хууль, Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 161 дүгээр тогтоол, НХХ-ийн сайдын 2009 оны 24 тоот тушаалаар зохицуулагддаг бөгөөд 2010 оны III улиралд 30466 иргэн хамрагджээ.

* * *

ДҮГНЭЛТ

Төрөөс иргэдэд 7 төрлийн тэтгэвэр, 12 төрлийн тэтгэмж, 6 төрлийн тусламж хөнгөлөлт, 3 төрлийн 10 зүйл халамж үйлчилгээ үзүүлж байна. Эдгээрт энгийн иргэд болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хэрхэн хамрагдаж байгааг тоймлон үзүүлвэл:

№	Төрөл	Санхүүжүүлэх эх үүсвэр	Нийт	Энгийн иргэд	ХБ иргэд
1.	Тэтгэвэр	НДС- гаас	3	1,5	1,5
		Халамжийн сангаас	4	2	2
2.	Тэтгэмж	НДС-гаас	5	3	2
		Халамжийн сангаас	8	4	4
3.	Тусламж, хөнгөлөлт	Халамжийн сан болон улсын төсвөөс	27	14	13
4.	Халамж үйлчилгээ	Халамж сан, ОУБ болон ААН-ийн хандив	10	5	5
5.	Бүгд		57	29,534	27,5

Хүснэгтээс харахад манай улсын энгийн иргэд болон ХБИ-ийн авч байгаа тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлт, халамж үйлчилгээ нь ижилхэн, ялгаваргүй байгаа нь харагдаж байна. Бүх үйлчилгээнээс тэтгэвэр - 7 буюу 12,28%, тэтгэмж - 13 буюу 22,81%, тусламж хөнгөлөлт – 27 буюу 47,37%, халамж үйлчилгээ -10 буюу 17,54% -ийг эзлэж байна.

Өнөөдөр Монгол Улсын 926780 иргэн тэтгэвэр, тэтгэмж, халамж үйлчилгээ, хөнгөлөлт тусламжид хамрагдаж байгаагаас тэтгэвэрт 358549 иргэн, тэтгэмжид 219431 иргэн, халамжид 21401 иргэн, хөнгөлөлт мөнгөн тусламжийн үйлчилгээнд 327399 иргэн хамрагдаж байна.⁸⁸ Хүний хөгжил санг оруулахгүй тооцвол манай улсад мөрдөж байгаа нийгмийн даатгал, халамжийн шугамаар энгийн иргэд болон тахир дутуу иргэдэд олгодог тэтгэвэр тэтгэмж тооны хувьд хангалттай бараг хэт хавтгайрсан, харин хүртээмжийн тухайд улс орны эдийн засгийн чадамжтай уялдан учир дутагдалтай байгааг анхаарч авах хүнээ олж цөөн тооны оновчтой тэтгэмжийг ахиухан хэмжээтэй олгох хувилбарыг сонгох зүйтэй байна.

Нийгмийн даатгалын сангаас 2010 онд тэтгэвэр тэтгэмж авсан хүний тоог Хавсралт №1⁸⁹-ээр, Халамжийн сангаас 2010 онд тэтгэвэр, тэтгэмж авсан хүний тоог Хавсралт №2⁹⁰-оор, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, халамж үйлчилгээ, хөнгөлөлт тусламжийн төрөл хэмжээг олгох эрх зүйн актыг Хавсралт №3⁹¹-д тус тус харуулав.

⁸⁸ НДЕГ болон ХХҮГ-ын 2010 оны 3 дугаар улирлын тайлан мэдээ /Хавсралт №1,2/

⁸⁹ НДЕГ-н 2010 оны 3 дугаар улирлын мэдээ

⁹⁰ ХХҮГ-ын 2010 оны 3 дугаар улирлын тайлан

⁹¹ Холбогдох тогтоол, тушаал эрх зүйн актаас

**Нийгмийн даатгалын сангаас 2010 оны 3 дугаар улирлын байдлаар нийт
тэтгэвэр тэтгэмж авагсадын тоо**

(Хавсралт №1)

Тэтгэвэр тэтгэмжийн төрөл		Хүний тоо
• Энгийн тэтгэвэр авагчид		280,847
1.	Өндөр нас	200,372
	Тахир дутуу	52,669
	Тэжээгчээ алдсаны	27,806
Цэргийн албан хаагчдын тэтгэвэр авагчид		13,999
1.	Өндөр нас	12,534
	Тахир дутуу	540
	Тэжээгчээ алдсаны	925
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр авагчид		7,026
1.	Тахир дутуу	6,318
	Тэжээгчээ алдсаны	708
Нийт тэтгэвэр авагчдын тоо		301,872
Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид		90,014
1.	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	59,365
	Жирэмсний, амаржсаны	19,880
	Оршуулгын	9,713
	Өвчтөн сахисны	1,056
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэмж авагчид		629
1.	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	629
Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авагчид		7,942
1.	Ажилгүйдлийн тэтгэмж	7,942
Нийт тэтгэмж авагчдын тоо		98,585
Нийт тэтгэвэр тэтгэмж авагчийн тоо		400,457

* * *

Халамжийн сангаас 2010 онд нийт тэтгэвэр тэтгэмж авагсдын тоо
/2010 оны жилийн эцэс/

Хавсралт №2

№	Тэтгэвэр тэтгэмжийн төрөл	Нийт хүний тоо
1.	Халамжийн тэтгэвэр	56,677
2.	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	120,846
	Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэнд олгох	15800
	Байнгын асаргаа шаардлагатай ХБ иргэнийг асарч байгаа	9410
	Байнгын асаргаа шаардлагатай ХБ хүүхдийг асарч байгаа	7267
	Бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж харгалзан дэмжигчид	2076
	Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа	626
	Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа	150
	Хүүхэд, төрөл садангүй, ганц бие ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа	274
	Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	85243
3.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн	21401
	Зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах	11746
	Хөдөлмөр эрхэлж, орлогын эх үүсвэртэй болоход нь туслах	2682
	Сэргээн засах үйлчилгээнд хамруулах	2601
	Түр байршуулан асрамжлах	2200
	Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах	638
	Нөхцөлт мөнгөн тэтгэмж авч байгаа асаргаа, сувилгаа үзүүлж байгаа иргэдэд зориулсан сургалтын зардал	1534
4.	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж /45+...+51/	154013
	Цэрцэрлэгийн хүүхдийн хоолны үнийн хөнгөлөлт	
	3 хүртэлхи насны ихэр хүүхдэд жилд нэг удаа	1476
	Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа	22012
	3 ба түүнээс дээш тооны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт жилд нэг удаа	1270
	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд нэг удаа	1050
	Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд нэг удаа	705
	Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж	127500

5.	Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж	136106
6.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж/	30466
7.	Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	6814
8.	Хүний хөгжил сангийн хишиг, хувь	2560900

* * *

ОХУ -ын хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмж, группын тэтгэвэр, нийгмийн хамгааллын талаархи зохицуулалт

“Оросын Холбооны Улсын хөдөлмөрийн тэтгэвэрийн тухай” Холбооны хуулийн дагуу 1,2,3 дугаар групптэй хүмүүс тахир дутуугийн тэтгэвэр авдаг ба тэтгэвэрийн хэмжээ нь тогтоосон тахир дутуугийн группээс хамаарна. Үүнд:

- ✓ 1 дүгээр групп - сард 5124 рубль
- ✓ 2 дугаар групп - сард 25262 рубль
- ✓ 3 дугаар групп - сард 1281 рубль

Түүнчлэн тахир дутуугийн тэтгэвэрийн хэмжээг тогтоохдоо хуулийн дагуу тодорхой тохиолдол бүрт бусад шалгуурийг мөн харгалздаг. Түүнчлэн 1999 онд батлагдсан “Төрийн нийгмийн тусламжийн тухай” Холбооны хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сар бүр нийгмийн үйлчилгээний төлбөр 641 рублийг олгодог ба үүнээс 570 рубль нь нэмэлт эмнэлгийн тусламж, 71 рубль нь төмөр зам болон эмчилгээний замын зардалд зориулан олгодог байна.

Дараах хүснэгтэнд ОХУ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сар бүр олгодог мөнгөн тэтгэлэгийн хэмжээг үзүүлэв.

№	Ангилал	Сар бүрийн мөнгөн төлбөрийн хэмжээ (руб.)	Нийгмийн үйлчилгээний төлбөрийн зэрэгцээ сар бүр төлөх мөнгөн төлбөрийн хэмжээ (НҮТ=641 руб.)	Төмөр замын тээврээр үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрхийн хамт сар бүр төлөх мөнгөн төлбөрийн хэмжээ	Үнэгүй эмээр хангагдах болон үнэ төлбөргүй сувилуулах эрхийн зэрэгцээ сар бүр төлөх мөнгөн төлбөрийн хэмжээ
1	Тахир дутуугийн I групп (3 түвшин)	2162.00	1521.00	2091.00	1592.00
2	Тахир дутуугийн II групп (2 түвшин)	1544.00	903.00	1473.00	974.00
3	Тахир дутуугийн III групп (1 түвшин)	1236.00	595.00	1165.00	666.00
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд	1544.00	903.00	1473.00	974.00

5	Хөдөлмөрийн чадвар алдалтын түвшин тогтоогоогүй тахир дутуу хүмүүс	772.00	131.00	701.00	202.00
---	--	--------	--------	--------	--------

Мөн “Оросын Холбооны улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай” Холбооны хуульд заасан ёсоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд орон сууцаар хангагдах, орон сууцны хөлс төлөхөд хөнгөлөлт үзүүлдэг болно.

ОХУ-ын 2001 оны “Хөдөлмөрийн тэтгэвэрийн тухай” Холбооны хуульд 2009 онд нэмэлт өөрчлөлт оруулсанаар 2010 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс хөдөлмөрийн суурь тэтгэвэрийн оронд хөдөлмөрийн тэтгэвэрийн даатгалын хэсгийг тогтоосон суурь хэмжээгээр тодорхойлох болсон байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн тэтгэвэрийн даатгалын хэсгийг индексжүүлсэн ба Засгийн газрын шийдвэрээр тухайн үеийн үнийн өсөлт, хөдөлмөрийн хөлсний сарын дундажтай уялдуулан индексийн коэффициентийг тодорхойлж байхаар болсон байна.

2011 онд л гэхэд ОХУ-д хөдөлмөрийн тэтгэвэрийг хоёр удаа индексжүүлжээ. Үүнд:

- 2011 оны 2 дугаар сарын 1-нээс хөдөлмөрийн тэтгэвэрийн хэмжээ 8,8 хувиар өссөн,
- 2011 оны 4 дүгээр сарын 1-нээс халамжийн тэтгэвэр 10,27 хувиар өсчээ.

ОХУ-ын тэтгэвэрийн хэмжээний өсөлт /2011 оны 2 дугаар сарын 1-ны байдлаар/

	Тэтгэвэрийн дундаж хэмжээ		2011.02.01-нээс хойш тэтгэврийн дундаж хэмжээний өсөлт
	2011.02.01-нээс өмнө	2011.02.01-нээс хойш	
Нийт хөдөлмөрийн тэтгэвэр авагсдын хувьд-Эдгээрээс:	7820	8498	678
Өндөр насны	8177	8886	709
Тахир дутуугийн	5147	5600	453
Тэжээгчээ алдсаны	4813	5236	423
Хоёр төрлийн тэтгэвэр авагсад:			
Цэргийн гэмтлийн улмаас тахир дутуу болсон	19075	20016	941
Эх орны дайнд оролцсон тахир дутуу иргэд	19278	20295	1017
Цэргийн албан хаагчдын бэлбэсэн гэргий нар	14169	14882	713
“Бүслэгдсэн Ленинградын оршин суугчид” тэмдэгтэй тахир дутуу иргэд	14478	15348	870

БНКаЗУлсын хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмж, группын тэтгэвэр, нийгмийн хамгааллын талаархи зохицуулалт

Казахстан улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмж, группын тэтгэвэр, нийгмийн хамгааллын асуудлыг 2005 онд батлагдсан “Бүгд Найрамдах Казахстан Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай”, 1997 онд батлагдсан “Бүгд Найрамдах Казахстан Улсын тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, өндөр насны нийгмийн тэтгэмжийн тухай” хуулиар тус тус зохицуулж байна.

БНКаЗУлсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тэтгэмж олгохдоо тэдгээрийг 5 ангилалд хуваадаг байна. 1 дүгээр ангилалд өвчний улмаас, хөдөлмөрийн явцад, мэргэжлийн өвчний улмаас тахир дутуу болсон мөн төрөлхийн тахир дутуу хүмүүсийг хамруулдаг ба эдгээрээс тахир дутуугийн 1 дүгээр групптэй хүмүүст сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,36 –тай тэнцэх хэмжээний тэтгэмж, тахир дутуугийн 2 дугаар групптэй хүмүүст хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,06 –тай тэнцэх хэмжээний тэтгэмж, тахир дутуугийн 3 дугаар групптэй хүмүүст хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0,74 –тэй тэнцэх хэмжээний тэтгэмж, 16 хүртэлх насны тахир дутуу хүүхдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,00–тэй тэнцэх, төрөлхийн тахир дутуу хүүхдэд тахир дутуугийн группээс нь хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,36-0,87-тай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгодог байна.

3 дугаар ангилал буюу хугацаат цэргийн албан хаагчдаас бусад хашиж буй албатай нь холбоогүйгээр золгүй явдлын улмаас тахир дутуу болсон цэргийн албан тушаалтнууд мөн тогтоогдсон тарих дутуугийн группээс хамааран 1 дүгээр ахглалын хүмүүстэй ижил хэмжээний иаигамж олгодог. 2, 5 дугаар ангилалын буюу хугацаат цэргийн алба хааж байхдаа тахир дутуу болсон хүмүүс ба иргэний болон цэргийн зориулалттай цөмийн объект дээр гарсан осолын улмаас, экологийн онцгой байдал, түүний дотор цөмийн дэлбэрэлт, туршилтийн үед цацраг туяаны улмаас тахир дутуу болсон хүмүүст мөн тэдгээрийн тахир дутуугийн группээс хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1,61-1,00 -тэй тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгодог байна.

4 дүгээр ангилал буюу хугацаат цэргийн албан хаагчдаас бусад цэргийн албаны үүрэг гүйцэтгэж байхдаа осолын улмаас тахир дутуу болсон цэргийн албан хаагчдад тогтоогдсон группээс хамааран хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2, 09-1,00 -тэй тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгож байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь нийгмийн хамгаалал, түүний дотор нөхөн сэргээгдэх, нийгэмтэйгээ хөл нийлүүлэн амьдрах, тоноглогдсон орон байраар хангагдах, үнэ төлбөргүй эмнэлгийн үйлчилгээ хүртэх эрх эдэлдэг.

Швед улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн халамж хамгаалал, тэтгэвэр тэтгэмжийн талаархи судалгаа

К. Марксын дэвшүүлсэн “Зүүний буюу Нийгмийн хамгааллын тухай ардчилсан социалист онол арга зүй” нь орчин үеийн нийгмийн ШУ-ны сэтгэлгээнд томоохон байр суурь эзэлдэг бөгөөд энэ нь онолын сэтгэлгээний ололт төдийгүй, “ардчилсан социализмын үзэл буюу Шведийн загварын хувилбар”-аар нийгмийн хөгжилд бодит биелэлээ олсон. Энэ онолын гол үндэслэл нь: - иргэн бүрийн ажил эрхлэлт - чинээлэг хангалуун амьжиргаа - олон ургальч үзэл - улс төрийн ардчилал - байгаль орчны хамгаалал зэрэг асуудлуудыг хамарч байв. Мөн энэ арга зүй нь одоогийн Европын Холбооны хэмжээнд баримталж байгаа нийгмийн баримжаат 33-ийн бодлогыг боловсруулах үндэс болсон. Сүүлийн үед зарим талаараа Шведийн загвар мухардалд ороод байгаа ч ардчилсан социалист үзэл зөвхөн Европт төдийгүй дэлхийн олон оронд, түүний дотроос Австрали, Япон, Монгол оронд ч хэсэгчлэн хэрэгжиж байна.

Швед Улсын “Хөдөлмөр эрхлэлтийг хамгаалах тухай акт”(1982), “Хөдөлмөр эрхлэлтийн орчин акт” (1977)-уудаар тэтгэвэрийн насыг тогтоох, ажиллах нөхцөл, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, сэтгэцийн болон биеийн хөгжлийн өөрчлөлтэй хүмүүст тохирсон ажлын байрны нөхцөлийг бүрдүүлэх, 18 насанд хүрээгүй боловч хуулинд заасан хөдөлмөр эрхэлж болох 16 насанд хүрсэн насанд хүрээгүйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, ажлаас халагдсаны нөхөн төлбөр, ажилгүй болсон ажилтанг эргүүлж авах нөхцөл, ажлын байрны аюулгүй байдал болон ажлын байрыг хадгалах зэрэг асуудлыг хуульчилсан байдаг байна.

Мөн түүнчлэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэхийг ялгаварлан гадуурхахыг хориглох акт” (1999) -аар хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажил олгогч ялгаварлан гадуурхахгүй байхыг дэлгэрэнгүй зүйлчилж өгсөн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ тэтгэвэр тэтгэмж болон нэмэлт үйлчилгээг Нийгмийн даатгалын тухай акт-1999, Нийгмийн хамгаалалын акт - 2001, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжлэг туслалцааны тухай акт-1988, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэмж болон асран хагаалах тухай акт-1998-уудаар тус тус зохицуулдаг байна.

Тахир дутуугийн байнгын тэтгэмж

Нийгмийн хамгаалалын системийн үүрэг:Энэ зорилгыг хэрэгжүүлэхийн тулд:

1. өвчлөх, өтлөх, осолдох, гэмтэх, ядуурах, орлогогүйдэх зэрэг хүмүүний амьдралын нийгмийн шинжтэй эрсдлээс ард иргэдийг хамгаалах үүргийг нийгмийн өмнөөс гүйцэтгэх.
2. Төрийн нийгмийн халамжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар иргэдийн амжиргааны доод түвшингийн баталгааг хангах.
3. Хүн ам зүй, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт гэх мэт төрийн нийгмийн бодлогыг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх гэсэн гурван үндсэн үүргийг нийгмийн хамгааллын систем гүйцэтгэдэг.

Нийгмийн хамгааллын тогтолцоог бүрэлдэхүүний хувьд нь:

1. Нийгмийн даатгал
2. Нийгмийн халамж
3. Нийгмийн бодлого дахь хамгааллын асуудлууд гэсэн 3 хэсэгт авч үзэх нь ихэнх оронд түгээмэл байна. Зах зээлийн харилцаа хөгжсөн орнуудад нийгэм хангамжийн дараахь таван төрлийн аргыг хэрэглэдэг.
 1. Нийгмийн даатгал
 2. Нийгмийн халамж
 3. Бүх нийтийн тэтгэврийн тогтолцоо
 4. Ажил олгогчийн буюу эздийн үүрэг хариуцлага
 5. Үндэсний нөөцийн сан

Нийгмийн даатгалын төрөл

Дараахи 5 төрөлтэй бөгөөд тус бүр бие даасан мөнгөн хөрөнгийн сантай. Сангийн хөрөнгийг шилжүүлэн зарцуулахыг хориглоно. Зориулалтын дагуу зарцуулна. Үүнд:

- Тэтгэврийн даатгал
- Тэтгэмжийн даатгал
- Үйлдвэрлэлийн осол,мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал
- Эрүүл мэндийн даатгал

- Ажилгүйдлийн даатгал

Нийгмийн даатгалын хэлбэр:

1. Заавал даатгал
2. Сайн дурын даатгал гэсэн 2 хэлбэртэй

ААНБ болон иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчид нь заавал даатгуулагч байна. Дээр зааснаас бусад иргэн хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бол сайн дураар даатгуулж болно.

НДСангийн орлого бүрдэлт:

НДС-н эх үүсвэр:

- Даатгуулагч болон ААНБ-аас төлөх шимтгэлийн орлого
- Улсын төвлөрсөн төсвөөс олгох хөрөнгө
- Сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү
- Шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд ногдуулах алданги
- Бусад эх үүсвэр

Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ:

Сангийн орлогын дийлэнхи хувийг шимтгэлийн орлого бүрдүүлдэг. НДС-ийг ажил олгогчид сар бүр цалингийн сангаас, даатгуулагч цалин түүнтэй адилтгах нийт орлогоосоо хуулинд заасан дараахи хувь хэмжээгээр төлнө.

Тэтгэврийн даатгал түүний шинэчлэл:

1. Тэтгэврийн даатгалын агуулга, төрөл
2. Тэтгэврийн даатгалын сан/ НДС/ -ийн эх үүсвэр, зарцуулалт
3. Тэтгэврийн даатгалын нэрийн данс түүний агуулга, ач холбогдол

Өтлөх, өнчрөх, бэлэвсрэх, осол гэмтэлд өртөх эрсдэлээс хамгаалах арга хэмжээг ихэнх оронд “Тэтгэврийн даатгал”-аар дамжуулан гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл өндөр насны, тэжээгчээ алдсаны, хөдөлмөрийн чадвараа удаан хугацаагаар алдсаны улмаас орлого нь буурсан, амьдралын хэвийн нөхцөл алдагдсан иргэдэд тэтгэвэр олгох замаар орлогын эрсдэлээс хамгаалах үүргийг тэтгэврийн даатгал гүйцэтгэдэг.

Тэтгэврийн даатгал нь 100 гаруй жилийн үүсэл, хөгжлийн түүхтэй, сүүлийн 50 жилд эрчимтэй хөгжиж, өөрчлөгдөж шинэчлэгдэж байгаа нийгмийн хамгааллын үндсэн чиглэлийн нэг юм. Иргэдийг ямар төрлийн эрсдлээс хамгаалах зорилгоос нь шалтгаалж 3 төрөлд ангилдаг. Үүнд:

1. Өндөр настны тэтгэвэр
2. Тэжээгчээ алдсны тэтгэвэр
3. Тахир дутуугийн тэтгэвэр

1. Өндөр насны тэтгэвэр

Тухайн улсын хууль тогтоомжид заасан тэтгэврийн насны болзлыг хангасан, нийгмийн даатгалын шимтгэлийг зохих хугацаанд төлсөн иргэдэд олгодог тэтгэврийг өндөр насны тэтгэвэр гэдэг бөгөөд тэтгэвэр олгох шалгуур нь тэтгэврийн нас юм. Тэтгэврийн насыг хуульчлан тогтоох, тэтгэврийн насаа өөрсдөө сонгох гэсэн хоёр үндсэн арга хэрэглэдэг. Ихэнх оронд тэтгэвэр олгох нийтлэг ба ердийн насыг хуульчлан тогтоодог бөгөөд 60-65

насандаа өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй боловч ажлын онцлог, хөдөлмөрийн нөхцөл, хүйс зэргээс шалтгаалан иргэд харилцан адилгүй наснаас тэтгэвэр тогтоолгох тохиолдол нилээд байдаг. Швед Улсын хувьд 67 нас хүртэл ажил логогчтэй гэрээ байгуулан хөдөлмөр эрхэлж болдог.

2. Хөдөлмөрийн чадвар алдалтын буюу тахир дутуугийн тэтгэвэр.

Хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар алдсан бие эрхтний эрсдэлтэй иргэдэд тахир дутуугийн тэтгэвэр олгодог. Энэ тэтгэврийг тогтооход "насны босго"-ыг харгалзахгүй төдийгүй шимтгэл төлсөн, ажилласан хугацаа нь харьцангуй бага байх боломжтой, ажиллах чадваргүй гэдгийг зөвхөн эмнэлэгийн үзүүлтүүдэд үндэслэдэг зэрэг нь түүний хамрах хүрээг нэмэгдүүлэхэд хүргэдэг.

3. Тахир дутуугийн тэтгэвэр

Мөн энэ төрлийн тэтгэврийн хэмжээ харьцангуй өндөр, авах хугацаа нь урт учраас ажилгүйдлийн г.м тэтгэвэр, тэтгэмж авахаасаа илүү хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох сонирхлыг иргэдэд илүүтэй бий болгодог сөрөг талууд ажиглагддаг. Англи, Швед, АНУ, Итали зэрэг орнууд хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэрт шинэчлэл хийснээр тэтгэврийн хуримтлалыг нэмэгдүүлэх нэг нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Тахир дутуугийн тэтгэвэр

Өөрчлөлт шинэчлэлийн гол мөн чанар нь эхлээд хүмүүсийн эрүүл мэндэд анхаарч дараа нь хөдөлмөрийн үйл ажиллагаанд дахин оролцуулах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Тахир дутуугийн тэтгэвэр авагчид нь тэтгэврийн насны болзлыг хангасан нөхцөлд өндөр насны тэтгэвэрт шилждэг.

3. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

Даатгуулагч буюу тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний асрамжид байсан хүмүүст тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох аргыг ихэнх оронд хэрэглэдэг. Энэ тэтгэвэр олгох гол шалгуур нь бэлэвсрэгчид, өнчрөгчид нь хөдөлмөрлөх чадваргүй байх, бага насны хүүхэд буюу тэтгэврийн насанд хүрсэн байх, амьдрах бэлгүй болсон байх зэрэг нөхцөлүүд ордог.

Тэтгэврийн хэлбэр

Үндэсний онцлог, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж ихэнх орон тэтгэврийн хоёр хэлбэрийг хэрэглэдэг.

1. Төрийн тэтгэврийн системд иргэдийг заавал хамруулах "суурь тэтгэвэр", ажиллагчдын орлогын "нэмэгдэл тэтгэвэр" хамрагддаг. Суурь тэтгэвэр нь нийт үндэсний шинжтэй, бүх иргэдийг хамрах тэдэнд амьдралын боломжит нөхцөлийг бүрдүүлэх зорилготой, эдийн засаг, нийгмийн өндөр хөгжилтэй Англи, Япон, Швейцар зэрэг орнуудад хэрэглэгдэж байгаа бөгөөд нэр нь "түгээмэл", "нийтлэг" "үндэсний" гэх зэргээр янз бүр байдаг
2. Хувийн тэтгэвэр: Төрийн тэтгэврийн бий болгож байгаа иргэдийн нэмэгдэл орлого хүссэн орон зайг зах зээлийн харилцаанд илүү тохирсон, даатгалын зарчимд тулгуурласан хувийн тэтгэврүүд эзлэдэг. Хувийн тэтгэврийн системийн гол шинж нь удирдлага бүтэц, санхүүжилт, ашиг тодорхойлох, ажлын хөлс, төлбөрийг тогтоох зэрэг нь чөлөөтэй байдаг боловч тодорхой эдийн засаг, нийгэм, эрх зүйн орон зайд төрийн зохих хэмжээний оролцоотой үүсч хөгждөг байна.

Чех Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн дэмжлэг, тахир дутуугийн тэтгэвэр

Тахир дутуугийн тэтгэврийг 2010 оны I сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн актын дагуу тогтоож олгодог байна.

1. Бүрэн тахир дутуугийн тэтгэвэр

Даатгалд хамрагдсан дор дурдсан иргэн бүрэн тахир дутуугийн тэтгэвэр авах эрхтэй:

- ✓ өндөр насны тэтгэвэр тогтоолгох болзол хангаагүй, бүрэн тахир дутуу иргэн
- ✓ Үйдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бүрэн тахир дутуу болсон иргэн

Тахир дутуугийн бүрэн тэтгэвэр нь Үндсэн ба нэмэгдэл тэтгэврээс бүрдэнэ. Хөдөлмө-рийн чадвараа 66 хувиас дээш алдсан иргэн насны хязгаараар даатгалын шимтгэл төлсөн байх болзлыг хангасан тохиолдолд олгодог.

- ✓ Суурь тэтгэвэр – 2170 крон
- ✓ Нэмэгдэл тэтгэвэр жилийн турш төлөх шитгэлийн тооцооны сууриас 1,5 хувь

2. Хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдсан тахир дутуу иргэдийн тэтгэвэр

Даатгалд хамрагдсан дор дурдсан иргэн тахир дутуугийн тэтгэвэр авах эрхтэй:

- ✓ Даатгалд хамрагдвал зохих хугацааны болзол, журмыг хангасан
- ✓ Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас тахир дутуу болсон

Тэтгэврийн хэмжээ 2 хэсгээс бүрдэнэ:

- ✓ Үндсэн тэтгэвэр – 2170 крон
- ✓ Нэмэгдэл тэтгэвэр жилийн турш төлөх шитгэлийн тооцооны сууриас – 0,75 хувь

3. Тахир дутуу иргэдэд үзүүлэх төрийн дэмжлэг

- ✓ Тахир дутуу хүүхэд бүхий гэр бүлийн дэмжлэг – хуанлийн сард 7600 крон/хүүхэд 7 нас хүртэл/
- ✓ Хүүхэд асарсны дэмжлэгийг өрхийн орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшингөөс 2 дахин илүү байхаар бодож олгоно.
- ✓ Өргөмөл хүүхдийн тэтгэмж – эрүүл хүүхэд амьжиргааны баталгаажих доод түвшинг 2,3 дахин удаан хугацааны өвчтэй хүүхдэд 2,9 дахин, тахир дутуу хүүхэд 3,1 дахин нэмэгдүүлж олгоно.
- ✓ Өргөж авсан эцэг, эхийн тэтгэмж. Хүүхдийн тооноос хамаарч 3 хүртэл насны хүүхдийн насны хүүхдэд амьжиргааны баталгаажих доод түвшингийн үнэлгээг 1-5,5 дахин өсгөж олгодог

4. Нийгмийн тусламж

Тахир дутуу иргэдэд тусгай хэрэгсэл худалдан авах, зориулалтын автомашин авах, засварлах, хүүгүй зээл зэрэг тогтоосон жагсаалтын дагуу нэг удаагийн нийгтийн тусламж олгодог.

Япон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр тэтгэмж, группын тэтгэвэр нийгмийн хамгаалалын талаар

Япон улсын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжлэгийн тухай хууль” 2005 онд батлагджээ.

28 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрахад зориулсан тэтгэмж

- ✓ Гэр оронд нь очиж үйлчилгээ үзүүлэх;
- ✓ Үйл ажиллагааны дэмжлэг, эрүүл мэндийн хамгаалал;
- ✓ Өдөр тутмын амьдралд үзүүлэх үйлчилгээ;
- ✓ Хүүхдийн өдрийн халамж, богино хугацаагаар асрах;
- ✓ Бүлгээр нь асрах байранд байлгах

28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Сургалтын төлбөрын тэтгэлэг:

- а) Нөхөн сэргээх үйлчилгээ;
- б) Хөдөлмөр эрхлэлтэд шилжихийг дэмжих;
- с) Бүлгээр нь дэмжих;

зэрэг тэтгэлгийг орон нутгийн байгууллага шийднэ.

29 дугаар зүйл. Зардлыг нь Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яам төлнө. Тэтгэлгийг 90 хүртэл хувиар төлөхийг хуулиар тогтоосон.

Тайлбар:

Эдгээр хуулиудын /Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль” 1966, “Хөдөлмөр эрхлэлтын аюулгүй байдлын тухай хууль” 1947, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжлэгийн тухай хууль” 2005/ хүрээнд авч үзвэл ихэвчлэн сургалтуудыг зохион байгуулан хэрэгжүүлж байна. Тодруулбал: Мэргэжлийн сургалт, ур чадварыг дээшлүүлэх сургалт болон техникийн дэвшил үйлдвэрлэлийн бүтцийн өөрчлөлттэй холбогдуулан шаардлагатай ур чадварын тест, сургалт, зөвлөгөөг боловсруулж Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яам тусгай зөвшөөрөл олгож, баталгаажуулдаг нь онцлог, ач холбогдолтой байна.

Хавсралт №3

МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ, ХӨНГӨЛӨЛТ ТУСЛАМЖИЙН ТӨРӨЛ, ХЭМЖЭЭ

д/д	Төрөл	Нэг удаа олгох мөнгөний хэмжээ / төгрөгөөр/	Олгох давтамж буюу хугацаа	Хэмжээ, хугацааг тогтоосон эрх зүйн баримт бичиг
-----	-------	---	----------------------------	--

А.НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР

1	Тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй	53,800	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
---	--	--------	---------	--

Судалгааны эмхтгэл, XI боть

2	Хууль ёсны тэжээн тэтгэгч нь ахмад настан, ХБИ бөгөөд тэдгээр нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй тогтоогдсон 60 ба түүнээс дээш насны эрэгтэй, 55 ба түүнээс дээш насны эмэгтэй	53,800	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
3	16 насанд хүрсэн одой иргэн	53,800	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
4	Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн ХБИ	53,800	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
5	16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг	53,800	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
6	Тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхэд	53,800	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол

Б.НӨХЦӨЛТ МӨНГӨН ТЭТГЭМЖ

1	Бүтэн өнчин хүүхдийг хууль ёсоор үрчлэн авсан болон хууль ёсоор асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
2	Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
3	Тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй ганц бие ахмад настан иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
4	Тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй, ганц бие ХБИ-тэй иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
5	Байнгын асаргаа шаардлагатай, ахмад настныг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
6	Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтад байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18 хүртэлх насны хүүхдийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол
7	Байнгын асаргаа шаардлагатай, эмнэлгийн хяналтад байдаг хөгжлийн бэрхшээлтэй 18-аас дээш насны хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэн	31,200	сар бүр	МУ-ын ЗГ-ын 2010 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 242 дугаар тогтоол

В. АМЖИРГААГ ДЭМЖИХ НӨХЦӨЛТ МӨНГӨН ТУСЛАМЖ

1	3 хүртэлх насны ихэр хүүхдэд жилд нэг удаа мөнгөн тусламж	60,000	жилд нэг удаа /хүүхдийн тоогоор/	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
2	Байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа мөнгөн тусламж	30,000	улиралд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
3	3 ба түүнээс дээш насны /14 хүртэлх насны/ хүүхдэдтэй өрх толгойлсон эх/эцэг/-т жилд нэг удаа	60,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
4	18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор нэг удаа	500,000	нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
5	Гэнэтийн аюул ослын улмаас орон гэргүй болсон өрхөд гэр авахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор нэг удаа	500,000	нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол

Г. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТҮШИГЛЭСЭН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

1	Амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох авьяасыг дэмжих зорилгоор зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах	14,500	7 хоногт	ХХҮГ-ын даргын 2010 оны ... тоот тушаалын 2-р хавсралт
2	Зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарахад нь туслах үйлчилгээ	1 сая төгрөг хүртэл	жилд нэг удаа	ХХҮГ-ын даргын 2010 оны ... тоот тушаалын 2-р хавсралт
3	Сэргээн засах үйлчилгээ	55,000	сард	ХХҮГ-ын даргын 2010 оны ... тоот тушаалын 2-р хавсралт
4	Түр байрлуулан асрамжлах	9,000	өдөрт	ХХҮГ-ын даргын 2010 оны ... тоот тушаалын 2-р хавсралт
5	Гэрийн асрамж халамжийн үйлчилгээ	48,400	сард	ХХҮГ-ын даргын 2010 оны ... тоот тушаалын 2-р хавсралт

Д. АХМАД НАСТАНД ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТ ТУСЛАМЖ

1	Хөл, гар, шүд/үнэт металлаар хийхээс бусад/-ний протезийн хэрэгсэл худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг 5 жил тутамд нэг удаа нөхөн олгох	Протез-ортопедийн хэрэгсэл тус бүр өөр үнэтэй	5 жилд нэг удаа	НХХСайдын 2009 оны 24 тоот тушаал
2	Сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг 5 жил тутам нэг удаа нөхөн олгох	Протез-ортопедийн хэрэгсэл тус бүр өөр үнэтэй	5 жилд нэг удаа	НХХСайдын 2009 оны 24 тоот тушаал

Судалгааны эмхтгэл, XI боть

3	Ахмадын зориулалттай амралт, сувилалын газарт амрах эрхийн бичгийг хөнгөлөлттэй үнээр олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
4	Тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг тусалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд орон сууцны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад нь үзүүлэх тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
5	Хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад нь үзүүлэх тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
6	Эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмад настан эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
7	Хүндэт донор ахмад настан дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
8	НД-ын тухай хууль тогтоомжинд заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, ганц бие ахмад настан нас барвал түүний оршуулгын зардалд олгох тусламж	225,000	нэг удаа	Нийгмийн халамжийн тухай хууль /НДСангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75%-тай тэнцэх хэмжээний тэтгэмж олгох тухай заалт/
9	Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
10	Ахмад настанд үзүүлсэн хүндэтгэл	хүлээн авч хүндэтгэл үзүүлнэ	жил бүр	«Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль

Е. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНД ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТ ТУСЛАМЖ

1	Бүрэн хараагүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд байрны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад жилд нэг удаа үзүүлэх мөнгөн тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
2	Бүрэн хэлгүй дүлий хөгжлийн бэрхшээлтэй иргэнд байрны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад жилд нэг удаа үзүүлэх мөнгөн тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол

3	Одой иргэнд байрны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад жилд нэг удаа үзүүлэх мөнгөн тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
4	Байнгын асаргаа шаардах, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд байрны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад жилд нэг удаа үзүүлэх мөнгөн тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
5	18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг 3 жил тутамд нэг удаа 100 хувь нөхөн олгох	Протез-ортопедийн хэрэгсэл тус бүр өөр үнэтэй	3 жилд нэг удаа	НХХСайдын 2009 оны 24 тоот тушаал
6	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалыг сангаас протез, сэргээн засалтын хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг 5 жил тутамд нэг удаа 100 хувь нөхөн олгох	Протез-ортопедийн хэрэгсэл тус бүр өөр үнэтэй	5 жилд нэг удаа	НХХСайдын 2009 оны 24 тоот тушаал
7	18 хүртэлхи насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез, сэргээн засалтын хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний худалдан авсан болон ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг 5 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох	Протез-ортопедийн хэрэгсэл тус бүр өөр үнэтэй	5 жилд нэг удаа	НХХСайдын 2009 оны 24 тоот тушаал
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн тусгай сургуульд ирж, очих унааны зардалд хөнгөлөлт үзүүлэх	90,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
9	Нийслэл болон хот суурин газарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн сургуульд хүүхдийг хүргэж өгөх, авах унааны зардалд жилд нэг удаа хөнгөлөлт үзүүлэх	90,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
10	Эмчилгээ, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд дотоодын рашаан сувилалд сувилуулбал нэг талын унааны зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль
11	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез, сэргээн засалтын хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэн дотоодын рашаан сувилалд сувилуулбал нэг талын унааны зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль

12	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх	тухай бүр	сар бүр	Хүүхдийн цэцэрлэгийн төлбөрийг төрөөс 100% даадаг болсонтой холбогдон зогссон
13	18 насанд хүрсэн бүрэн хараагүй иргэний харилцаа, холбооны төлбөрт хөнгөлөлт үзүүлэх	10,000	сар бүр	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
14	Нийслэлийн 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эсхүл иргэн аймгийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль
15	Хараагүй хүний брайлын үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	тухай бүр	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль
16	Бүрэн хараагүй иргэн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчих шаардлагатай болвол ирж буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль
17	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль
18	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулыг тэтгэмж авах эрх үүсээгүй, ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэн нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75 хувьтай тэнцэх хэмжээний тусламж олгох	225,000	нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль /НДСангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75%-тай тэнцэх хэмжээний тэтгэмж олгох тухай заалт/
19	Хараагүй хүнд зориулсан брайль болон томруулсан үсэгтэй ном, сурах бичиг, сонин сэтгүүл хэвлэх зардлыг нийгмийн халамжийн сангаас гаргах	судалгааны үндсэн дээр олгох	жилд нэг удаа	«Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай» хууль

Ё. АЛДАР ЦОЛТОЙ АХМАД НАСТАНД УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОЖ БАЙГАА ТУСЛАМЖ

1	Монгол улсын болон хөдөлмөрийн баатар, ардын цолтон, ахмад дайчин, түүнчлэн дайнд оролцож яваад амь үрэгдсэн эхнэр / нөхөрт/ -т сар бүр мөнгөн тусламж	200,000	сар бүр	УИХ-ын 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 33 дугаар тогтоол
2	Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын цолтон болон гавьяат цолтон, төрийн соёрхолт, ахмад дайчин, ударник, ХТАЗ-д үзүүлэх хөнгөлөлт	150,000	сар бүр	УИХ-ын 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 33 дугаар тогтоол
Ахмад дайчдын орон сууц		30000000 төгрөгийн үнэтэй	нэг удаа	МУ-ын Ерөнхийлөгчийн 2008 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 170 дугаар зарлиг

Ж. МОНГОЛ УЛСЫН БААТАР, ХӨДӨЛМӨРИЙН БААТАР, АРДЫН БОЛОН ГАВЬЯАТ ЦОЛТОН АХМАД НАСТАНД ТӨРӨӨС ОЛГОХ НЭМЭГДЛИЙН ТУХАЙ

1	Монгол Улсын гавьяат, төрийн соёрхолт, улсын ударник, ХТАЗүтгэлтэн ахмад настанд жилд нэг удаа мөнгөн тусламж	100,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
2	Нийслэлээс аймагт аймгаас нийслэлд ирэх, буцах замын зардлыг жилд нэг удаа олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	дээрх хуулийн дагуу
3	Дотоодын рашаан сувилалд ирэх, буцах, замын зардал эрхийн бичгийн үнийг жилд нэг удаа нөхөн олгох	орон нутгийн тарифт үнээр тооцон олгох	жилд нэг удаа	дээрх хуулийн дагуу
4	Орон сууцны хөлс төлөх, түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
5	Орон сууцны хөлс төлөх, түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламжийг 2 дахин нэмэгдүүлж авсан ахмад настан	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
6	Төрийн өндөр албан тушаал хашиж байсан ахмад настанд түлээ, нүүрс авах тусламж	140,000	жилд нэг удаа	МУЗГ-ын 2008 оны 161 дүгээр тогтоол
Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр		том хүн - 10,000 хүүхэд - 5,000	сар бүр	НХХсайд, Сангийн сайдын 2009 оны 152/251 дугаар хамтарсан тушаал

З. ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛИЙН УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ

1	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	зогсоогдсон
2	Шинэ төрсөн хүүхдэд 1 удаа олгох мөнгөн тусламж	
3	Шинэ гэр бүлд 1 удаа олгох мөнгөн тусламж	

Судалгааны эмхтгэл, XI боть

4	Эхийн алдар одонтой эхчүүдэд жилд 1 удаа олгох мөнгөн тусламж	1-р одон - 200,000 2-р одон - 100,000	жилд нэг удаа	УИХ-ын 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоол
5	Жирэмсэн болон хөхүүл нярай хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	26,000	сар бүр	УИХ-ын 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 54 дүгээр тогтоол

И. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИАР ИРГЭН БҮРТ ОЛГОХ ХИШИГ ХУВЬ

1	Монгол улсын иргэн бүрт олгох хишиг хувь	21,000	сар бүр	Хүний хөгжил сангийн 2011 оны төсвийн тухай хууль
---	--	--------	---------	---



UIH.MN
СУДАЛГААНЫ САН